

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ баримт бичгээр комплайнсын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд комплайнсын нэгж/ажилтан нь хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам стандартуудыг судалж, компанийн дотоодод мөрдөгдөх дүрэм, журам зааврыг хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлж ажиллахад оршино.

Хоёр. Зорилго

2.1 Комплайнсын хяналтын зорилго нь:

2.1.1 Эрсдэлийн удирдлагыг бий болгох замаар компанийн засаглалыг сайжруулах

2.1.2 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх

2.1.3 Байгууллагын комплайнсын соёлыг бүрдүүлэх, төлөвшүүлэх, сургалт зохион байгуулах

2.1.4 Зөрчлийн талаар мэдээлэх "шүгэл үлээх" ажиллагааг хэрэгжүүлэх оршино.

Гурав. Үндсэн зарчим

3.1 Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.1.1 Хараат бус бие даасан байх

- Комплайнсын хяналтын үйл ажиллагаа албан ёсны бие даасан байна.
- Комплайнсын нэгж/ажилтантай байна.
- Сонирхлын зөрчлөөс ангид байна.
- Комплайнсыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөвтэй байна.

3.1.2 Ил тод нээлттэй байх

- Комплайнсын нэгж/ажилтан холбогдох дотоод нэгжээс мэдээлэл гаргуулах, мэдээлэх
- Комплайнсын нэгж/ажилтан байгууллагын бусад нэгжүүд болон дотоод хяналтын нэгжтэй хамтран ажиллах

Дөрөв. Комплайнсын хяналтын зааврыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл

4.1 Комплайнсын хяналтын зааврыг хэрэгжүүлэх үндсэн тогтолцоог/чиглэлийг дараах түвшинд тодорхойлно. Үүнд:

4.1.1 ТУЗ-ийн чиг үүрэг:

4.1.1.1 Бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, зааврыг батална.

4.1.1.2 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр байгууллагын эрсдэлийн түвшин, онцлогт нийцсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.